



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

2025



Улаанбаатар хот

2026 он

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТ



2025

Улаанбаатар хот
2026 он

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

Б.ШИНЭЦЭЦЭГ

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Г.ЧИНЖАРГАЛ

ХЭЛТСИЙН ДАРГА

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
27-р хороо, Замчдын гудамж-3
Засаг даргын Тамгын газрын байр 112, 114 тоот
Утас: 11-301637, 70122688
Цахим хаяг: bayangol@nso.mn
Цахим хуудас: <http://www.1212.mn>
<http://www.ubstat.mn>
<http://www.bgd.mn>



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО, жид бүрийн эцэст.....	7
ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАГЧДЫН ТОО, дүүргээр, жил бүрийн эцэст	9
ХҮСНЭГТ 3. АЖИЛЛАГЧДЫН ТОО, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эцэст	10
ХҮСНЭГТ 4. АЖИЛЛАГЧДЫН ТОО, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст	10
ХҮСНЭГТ 5. АЖИЛЛАГЧДЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, жил бүрийн эцэст	11
ХҮСНЭГТ 6. АЖИЛГҮЙ ИРГЭД, дүүргээр, жил бүрийн эцэст	11
ХҮСНЭГТ 7. АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эцэст	12
ХҮСНЭГТ 8. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, дүүргээр, жил бүрийн эцэст	14
ХҮСНЭГТ 10. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, хүйсээр, ажилгүй байгаа шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст	15
ХҮСНЭГТ 11. БОЛОМЖИТ АЖИЛЛАХ ХҮЧ, хүйсээр, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст	16
ХҮСНЭГТ 12. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ, хүйсээр, насны бүлгээр, 2025 оны жилийн эцэст	Error! Bookmark not defined.16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО, 2025 оны жилийн эцэст	6
ЗУРАГ 2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, АЖИЛЛАГЧДЫН ТОО, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, жил бүрийн эцэст	8
ЗУРАГ 3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, жил бүрийн эцэст	8
ЗУРАГ 4. АЖИЛЛАГЧДЫН ТОО, нас хүйсийн суваргаар, 2025 оны жилийн эцэст	9
ЗУРАГ 5. НИЙСЛЭЛИЙН АЖИЛГҮЙ ИРГЭД, дүүргээр, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцэст	12
ЗУРАГ 6. АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, хүйсээр, 2025 оны жилийн эцэст	13
ЗУРАГ 7. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, улс, нийслэлд эзлэх хувиар, жил бүрийн эцэст	13
ЗУРАГ 8. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, насны бүлгээр, хүйсээр, 2025 оны жилийн эцэст	14



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Дүүргийн ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өслөө.

Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд нь хүн амын насны бүтэц, боловсролын байдлаас шууд хамаардаг бөгөөд "Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг Үндэсний Статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2009 онд шинэчлэн баталснаар хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг "Ажиллах хүчний судалгааны"-ны үр дүнгээс тооцож байна.


"Статистикийн тухай" Монгол улсын хуулинд

2004 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2006 оноос эхлэн "Ажиллах хүчний судалгаа"-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн тархаадаг болсон юм. Ажиллах хүчний судалгаанд дүүргийн 34 хорооноос сонгогдсон өрхөөс мэдээллийг сар бүр цуглуулж, улирлаар нэгтгэж үр дүнг тархаадаг.

Ажиллах хүчний судалгаагаар 2025 онд Баянгол дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны 173.0 мянган хүн байгаагийн 78.6 (45.4%) мянга нь эрэгтэй, 94.4 (54.6%) мянга нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 1.

АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО, 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСТ



Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцооноос харвал 105388 (60.9%) нь ажиллах хүч 67641 (39.1%) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч 8925 (9.3%) хүнээр өсөж, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 1153 (1.7%)-аар буурсан байна.

Ажиллах хүчний 101512 (96.3%) нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчид, 3876 (3.7%) нь хөдөлмөрийн дутуу ашиглалтын нэг бүлэг болох ажилгүй хүн байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт 2025 оны эцэст дүүргийн хэмжээнд 6549 байгаагийн 3876

(59.2%) нь ажилгүй хүн, 2536 (38.7%) нь боломжит ажиллах хүч, 137 (2.1%) нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна.

Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 2536 (3.7%) нь боломжит ажиллах хүч, 65105 (96.3%) нь өргөтгөсөн ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Боломжит ажиллах хүчний бүлэг нь тухайн орон нутагт ажлын байр бий болох эсвэл ажил хийх нөхцөл бүрдвэл хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож эхлэх, ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа хүн ам юм. Энэ утгаараа ажиллах хүчинд ороход боломжит бүлэг гэж үзэн, ажиллах хүчинд нэмж, өргөн утгаар нь өргөтгөсөн ажиллах хүч гэж авч үздэг.

ХҮСНЭГТ 1.

АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025 2024	
	тоо					зөрүү	хувь
Бүгд	152 452	153 827	157 579	165 257	173 026	7 769	4.7
Ажиллах хүч	76 323	85 256	79 619	96 463	105 388	8 925	9.3
Ажиллагчдын тоо	68 150	80 678	75 971	91 822	101 512	9 690	10.6
Ажилгүй хүн	8 173	4 578	3 648	4 641	3 876	-765	-16.5
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	-	509	221	225	137	-88	-39.1
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	76 129	68 571	77 960	68 794	67 641	-1 153	-1.7
Боломжит ажиллах хүч	4 291	3 357	1 770	1 552	2 536	984	63.4
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	71 838	65 214	76 190	67 242	65 105	-2 137	-3.2
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	50.1	55.4	50.5	58.4	60.9	-	4.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	44.7	52.4	48.2	55.6	58.7	-	5.6
Ажилгүйдлийн түвшин, %	10.7	5.4	4.6	4.8	3.7	-	-22.9
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	10.7	6.0	4.9	5.0	3.8	-	-24.0
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %	15.5	9.5	6.9	6.3	6.1	-	-3.2


Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг үнэлэх дөрвөн үзүүлэлтийг 2025 оны байдлаар авч үзэхэд хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 6.1 хувь, ажилгүйдлийн түвшин 3.7 хувь байна. Харин ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 6.1 хувь, цаг

хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 3.8 хувь байна.

Баянгол дүүрэгт 2025 оны байдлаар ажил эрхэлдэг хүн 101512 болж өнгөрсөн оноос 9690 (10.6%) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 2.

АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, АЖИЛЛАГЧДЫН ТОО, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, жил бүрийн эцэст




Дүүргийн ажилгүйдлийн түвшин 3.7 байгаа нь ажиллах хүчний 100 хүн тутамд 4 нь ажилгүй байгааг харуулж байна. Ажилгүйдлийн түвшин өнгөрсөн оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурсан эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Хөдөлмөрийн насны хүн амын бүтцийн өөрчлөлтийн улмаас ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 3.1 нэгж хувиар тус бүр өссөн байна.

ЗУРАГ 3.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, жил бүрийн эцэст



Ажиллах хүчний оролцооны түвшин буюу хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний эзлэх хувийн жин 60.9 хувь болж өмнөх оны мөн үеэс 2.5 нэгжээр өссөн байна.

Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.7 хувь болж өмнөх оны мөн үеэс 3.1 нэгжээр өссөн байна.

Ажиллагчид: Ажиллах хүчний судалгааны дүнгээр эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн салбарт ажиллагчдын тоо 2025 онд улсын хэмжээнд 1359.0 мянга байгаагийн 637.8 (46.9%) нь Улаанбаатар хотод, 101.5 (7.5%) нь Баянгол дүүрэгт амьдарч байна.

ХҮСНЭГТ 2.

АЖИЛЛАГЧДЫН ТОО, дүүргээр, жил бүрийн эцэст


Дүүрэг	2021	2022	2023	2024	2025	2025 2024	
	тоо					зөрүү	хувь
Нийслэлийн дүн	475 806	534 712	549 011	627 516	637 803	10 287	1.6
Багануур, Багахангай, Налайх	14 954	18 915	21 551	27 817	22 289	-5 528	-19.9
Баянгол	68 150	80 678	75 971	91 822	101 512	9 690	10.6
Баянзүрх	127 647	138 682	153 046	170 537	176 070.3	5 533.3	3.2
Сонгинохайрхан	109 292	118 287	116 962	131 857	128 627	-3 230	-2.4
Сүхбаатар	44 489	47 298	53 568	55 621	51 373	-4 248	-7.6
Хан-Уул	63 312	78 399	83 752	101 923	109 728	7 805	7.7
Чингэлтэй	47 962	52 453	44 161	47 939	48 204	265	0.6
Нийслэлд эзлэх %	14.3	15.1	13.8	14.6	15.9	-	-

Нийт ажиллагчдын 176.1 (27.6%) мянга нь Баянзүрх, 128.6 (20.2%) мянга нь Сонгинохайрхан, 109.7 (17.2%) мянга нь Хан-Уул, 101.5 (15.9%) мянга нь Баянгол, 51.4 (8.1%)

мянга нь Сүхбаатар, 48.2 (7.6%) мянга нь Чингэлтэй, 6.8 (1.1%) мянга нь Багануур, Багахангай, 15.5 (2.3%) мянга нь Налайх дүүрэгт тус тус амьдарч байна.

ЗУРАГ 4.

АЖИЛЛАГЧДЫН ТОО, нас хүйсийн суваргаар, 2025 оны жилийн эцэст



Ажиллагчдын 8424 (8.3%) нь 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 86993 (85.7%) нь 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан), 6095 (6.0%) нь 55 ба түүнээс дээш насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) байна.

ХҮСНЭГТ 3. АЖИЛЛАГЧДЫН ТОО, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн эцэст

Насны бүлэг	2021		2022		2023		2024		2025	
	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
	тоо									
Бүгд	68 150	31 428	80 678	36 727	75 971	36 824	91 822	41 329	101 512	46 602
15-24	4 287	1 837	5 087	2 340	4 754	1 990	6 676	3 264	8 424	2 963
25-29	24 273	11 837	25 739	10 784	16 146	7 963	33 096	13 467	30 099	11 793
35-39	24 695	9 596	26 757	11 801	31 183	15 259	28 398	13 835	29 769	13 104
45-49	9 794	5 913	17 499	9 360	18 467	9 067	14 768	6 783	27 125	14 717
55 +	5 101	2 245	5 596	2 442	5 421	2 545	8 884	3 980	6 095	4 025

2025 онд дүүргийн нийт ажиллагчдын 54.1 хувийг эрэгтэй, 45.9 хувийг эмэгтэй ажиллагчид тус тус эзлээд байна. Ажиллагчдыг өмнөх онтой харьцуулахад эрэгтэй ажиллагчид 4417 (8.7%) хүнээр, эмэгтэй ажиллагчид 5273 (12.8%) хүнээр өссөн байна.

Хөдөлмөр эрхэлж буй хүн амыг ажил мэргэжлийн ангилалаар нь задалбал 29636 (29.2%) нь мэргэжилтэн, 20854 (20.5%) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 13802 (13.6%) нь менежер, 12851 (12.7%) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 9672 (9.5%) нь машин

Нийт мэргэжилтнээр ажиллаж байгаа иргэдийн 8424 (8.3%) нь 15-24 насныхан, 30099 (29.7%) нь 25-29 насныхан, 29769 (29.3%) нь 35-39 насныхан, 27125 (26.7%) нь 45-54 насныхан эзэлж байгаа бол үлдсэн 6095 (6.0%) нь 55-аас дээш насныхан эзэлж байна.

механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, 3651 (3.6%) нь техникч болон туслах дэд мэргэжилтэн, 2580 (2.5%) контор үйлчилгээний ажилтан, 7843 (7.7%) нь энгийн ажил, мэргэжил, 623 (0.7%) бусад ажилтнаар тус тус ажил эрхэлж байна.

ХҮСНЭГТ 4. АЖИЛЛАГЧДЫН ТОО, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст

Дүүрэг	2022	2023	2024	2025	2025 2024
	Тоо				хувь
Бүгд	80 678	75 971	91 822	101 512	10.6
Менежер	10 072	7 408	10 892	13 802	26.7
Мэргэжилтэн	27 368	23 663	33 075	29 636	-10.4
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	4 171	2 322	5 103	3 651	-28.5
Контор, үйлчилгээний ажилтан	3 256	4 202	3 408	2 580	-24.3
Худалдаа, үйлчилгээний ажилтан	15 261	15 923	20 877	20 854	-0.1
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	9 563	10 618	8 370	12 851	53.5
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	7 122	6 747	6 862	9 672	41.0
Энгийн ажил, мэргэжил	3 357	4 867	2 683	7 843	2.9**
Бусад	508	221	552	623	12.9

**-дахин их

Хөдөлмөр эрхлэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараас харвал өнгөрсөн жилээс уул уурхай, олборлолт 123.0 хувиар, боловсруулах үйлдвэрлэл 17.1 хувиар,

барилгын салбар 66.8 хувиар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 42.4 хувиар, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 57.3 хувиар, боловсролын салбар 5.5

хувиар, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 24.5 тус тус өссөн бол харин зарим салбарууд буурсан төлөвтэй байгаа бөгөөд энэ дундаа бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ 1.7 хувиар, санхүүгийн болон

даатгалын үйл ажиллагаа 15.1 хувиар, боловсруулах үйлдвэрлэл 11.7 хувиар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагааны салбар 17.8 хувиар, бусад салбар 30.3 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 5.**АЖИЛЛАГЧДЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, жил бүрийн эцэст**

Салбарын ангилал	2021	2022	2023	2024	2025	<u>2025</u> <u>2024</u>
	тоо					хувь
Бүгд	68 150	80 678	75 971	91 822	101 512	10.6
Уул уурхай, олборлолт	3 462	3 968	5 198	2 858	6 374	123.0
Боловсруулах үйлдвэрлэл	6 736	8 749	9 399	8 298	9 716	17.1
Барилга	8 767	8 444	9 068	6 818	11 375	66.8
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	14 501	14 549	14 706	21 685	21 307	-1.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4 289	6 511	3 539	7 887	11 228	42.4
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3 468	2 543	2 766	4 022	6 325	57.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2 856	2 747	2 764	4 714	4 003	-15.1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын	2 650	4 375	5 418	6 236	5 124	-17.8
Боловсрол	6 943	6 308	6 193	6 265	6 609	5.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3 058	6 104	5 197	6 191	7 706	24.5
Бусад	11 420	16 380	11 723	16 848	11 745	-30.3

Нийт ажиллагчдын хамгийн их нь буюу 21.0 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт, харин хамгийн бага нь буюу 3.9 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа явуулдаг салбарт тус тус ажиллаж байна.

Ажилгүй хүн: Дүүргийн хэмжээнд ажилгүй хүн 2025 оны байдлаар 3876 байгаагийн 3014 (77.8%) нь эрэгтэйчүүд, 862 (22.2%) нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй иргэд өмнөх оноос 765 (16.5%) хүнээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.


ХҮСНЭГТ 6.**АЖИЛГҮЙ ИРГЭД, дүүргээр, жил бүрийн эцэст**

Дүүрэг	2021	2022	2023	2024	2025	<u>2025</u> <u>2024</u>	
	тоо					зөрүү	хувь
Нийслэлийн дүн	41 097	32 021	28 286	38 620	28 853	-9 767	-25.3
Багануур, Багахангай, Налайх	313	2 228	1 036	2 819	1 700	-1 119	-39.7
Баянгол	8 173	4 578	3 648	4 641	3 876	-765	-16.5
Баянзүрх	11 650	6 968	10 697	5 880	7 784	1 904	32.4

Дүүрэг	2021	2022	2023	2024	2025	2025 2024	
	тоо					зөрүү	хувь
Сонгинохайрхан	6 711	7 749	4 492	12 753	7 299	-5 454	-42.8
Сүхбаатар	3 840	2 887	2 269	3 685	1 939	-1 746	-47.4
Хан-Уул	5 471	5 038	2 877	5 494	3 399	-2 095	-38.1
Чингэлтэй	4 939	2 573	3 267	3 348	2 856	-492	-14.7

ЗУРАГ 5.

НИЙСЛЭЛИЙН АЖИЛГҮЙ ИРГЭД, дүүргээр, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцэст



Ажиллах хүчний судалгааны дүнгээр улсын хэмжээнд нийт 78350 иргэн ажил идэвхтэй хайж байгаа, ажилгүй гэж бүртгүүлснээс Нийслэлд нийтдээ 28854 (26.8%) хүн ажилгүй байгаа ба үүнээс 3876 (4.9%) ажилгүй иргэн тус дүүрэгт амьдарч байна. Харин ажилгүй иргэдийг нийслэлийн дүнд эзлэх хувиар авч үзвэл 7.3 (25.3%) мянга нь Сонгинохайрхан, 7.8 (27.0%) мянга нь Баянзүрх, 3.4 (11.8%) мянга нь Хан-Уул, 3.9 (13.4%) мянга нь Баянгол, 1.9 (6.7%) мянга нь Сүхбаатар, 2.9 (9.9%) мянга нь Чингэлтэй, 1.7 (5.9%) мянга нь Налайх, Багануур, Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Ажилгүй хүний тоо өмнөх оны мөн үеэс 25-34 насны бүлэгт 603 (68.2%) хүнээр, 45-54 насны бүлэгт 228 (91.6%) хүнээр, 55-аас дээш насныхан 40 (12.1%) хүнээр тус тус өссөн сөрөг

үр дүн гарсан бол 15-24 насны бүлэгт 1188 (83.1%) хүнээр, 35-44 насны бүлэгт 367 (20.5%) хүнээр, 55-аас дээш насныхан 41 (14.1%) тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 7.


АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эцэст

Насны бүлэг	2021		2022		2023		2024		2025		2025 2024	
	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
	тоо										хувь	
Бүгд	8 173	3 272	4 578	1 119	3 648	1 658	4 641	2 414	3 876	862	-16.5	-64.3
15-24	611	203	407	305	-	-	1 429	930	241	121	-83.1	-87.0
25-34	1 841	1 024	1 526	306	774	221	884	717	1 487	112	68.2	-84.4
35-44	3 471	1 021	814	203	1 216	553	1 788	349	1 421	458	-20.5	31.2
45-54	2 250	1 024	1 526	203	1 327	663	249	127	477	171	91.6	34.6
55+	-	-	305	102	331	221	291	291	250	-	-14.1	-

Дүүргийн хэмжээнд 2025 оны байдлаар 15-24 насны 241 (6.2%) ажилгүй залуучууд байгаа бөгөөд 25-44 насны 2908 ажилгүй залуучууд байгаа нь нийт ажилгүй хүмүүсийн 75.0 хувийг

эзэлж байна. Сүүлийн 5 үзүүлэлтийг харьцуулахад 2021 оноос 52.6 хувиар, 2022 оноос 15.3 хувиар, 2024 онд 16.5 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй гарсан бол 2023 оноос 6.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


ЗУРАГ 6.

АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, хүйсээр, 2025 оны жилийн эцэст

Хөгжиж буй ихэнх орнуудад гол төлөв боловсрол доогуур буюу боловсролгүй хүн ам ажилгүй байдаг бол манай улсад боловсролтой иргэд илүү ажилгүй байх хандлагатай байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам: Дүүргийн хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 67.6 (39.0%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

ЗУРАГ 7.

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, улс, нийслэлд эзлэх хувиар, жил бүрийн эцэст

Монгол Улсад ажиллах хүчнээс гадуурх нийт 916.2 мянган хүн амьдарч байгаа бөгөөд үүний 471.4 (51.5%) мянган иргэн Улаанбаатар хотод амьдарч байна. Нийт эдгээр нийслэл хотод

амьдарч байгаа хүн амаас харвал Баянзүрх дүүрэгт хамгийн их 123.5 (26.2%) мянга нь, харин хамгийн бага нь 27.3 (5.8%) мянга нь Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд байна.

ХҮСНЭГТ 8.


АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, дүүргээр, жил бүрийн эцэст

Дүүрэг	2021	2022	2023	2024	2025	2025 2024	
	тоо					зөрүү	хувь
Нийслэлийн дүн	499 792	468 241	534 885	475 625	471 446	-4 179	-0.9
Багануур, Багахангай, Налайх	20 833	25 898	28 591	23 563	27 306	3 743	15.9
Баянгол	76 129	68 571	77 960	68 795	67 641	-1 154	-1.7
Баянзүрх	123 029	113 699	130 501	126 971	123 506	-3 465	-2.7
Сонгинохайрхан	113 292	109 661	116 802	103 565	94 840	-8 725	-8.4
Сүхбаатар	55 339	45 430	46 934	41 011	45 671	4 660	11.4
Хан-Уул	60 781	57 509	80 725	65 608	71 763	6 155	9.4
Чингэлтэй	50 389	47 473	53 372	46 112	40 720	-5 392	-11.7

Баянгол дүүрэгт 2025 оны жилийн эцэст ажиллах хүчнээс гадуурх хүн ам 67641 байгаа ба 2024 онтой харьцуулахад 1.7 хувиар буурсан үр дүн гарчээ. Эдгээрийн 38.8 хувь нь эрэгтэй, 61.2 хувь нь эмэгтэй байна.

ЗУРАГ 8.

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, насны бүлгээр, хүйсээр, 2025 оны жилийн эцэст



Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг насны бүлгээр авч үзвэл 47.3 (34.%) мянга нь 55-аас дээш тэтгэврийн насныхан байгаа бол харин ажил, хөдөлмөр эрхлэх боломжтой буюу 15-54 насныхан нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амын 67.9 хувийг эзэлж байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг шалтгаанаар нь авч үзэхэд 47.3 (34.9%) мянга нь суралцдаг, сурахаар явж байгаа, 40.7 (30.1%) мянга нь 55-аас дээш тэтгэврийн насныхан тус тус эзлээд байна.

ХҮСНЭГТ 9.

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, шалтгаанаар, хүйсээр, 2025 оны жилийн эцэст

Шалтгаан	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55+	Бүгд
Ажиллах сонирхолгүй байсан	-	-	-	116	-	-	-	-	-	116
Бусад	-	162	133	-	-	-	-	-	-	295
Гадаадад амьдарч байгаад ирсэн	-	-	-	456	116	-	-	-	-	572
Жирэмсэн/хүүхэд асарсан	303	1 041	4 613	2 544	3 589	747	286	403	-	13 526
Мэргэжил, дадлага туршлага байхгүй	-	-	-	132	-	-	-	87	-	219
Мэргэжилд тохирох ажил олдохгүй	-	-	-	127	-	-	-	-	-	127
Өвчтөн, өндөр настан асарсан	-	-	-	-	381	90	110	505	494	1 580
Өвчтэй	106	-	101	112	187	417	454	790	384	2 551
Суралцдаг, сурахаар явж байгаа	17 019	6 150	314	147	-	-	-	-	-	23 630
Тэтгэвэрт гарсан, өндөр настан	-	-	-	-	-	-	-	672	19 698	20 370
Улирлын чанартай ажил хийдэг болохоор	-	-	142	-	124	-	108	147	-	521
Хөгжлийн бэрхшээлтэй	195	267	160	497	299	126	728	105	1 166	3 543
Хүүхдээ сургуульд сургахаар	-	-	-	-	-	101	136	106	-	343
Цалин бага учраас	-	-	-	129	-	119	-	-	-	248
Бүгд	17 623	7 620	5 463	4 260	4 696	1 600	1 822	2 815	21 742	67 641

Боломжит ажиллах хүч:

Дүүргийн хэмжээнд 2025 оны байдлаар нийт хөдөлмөрийн дутуу ашиглалтын 2537 хүн цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажилтай хүний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүчинд багтаж байна. Эдгээр иргэд нь ажилгүй хүнтэй адил хөдөлмөрийн зах зээлд бүрэн ашиглагдахгүй байгаа хөдөлмөрийн нөөц гэж тооцогддог. Учир нь боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүнийг хэлнэ.

Улсын хэмжээнд нийт боломжит ажиллах хүч 31565 байгаагаас 22244 (70.5%) нь Улаанбаатар хотод, 2537 (8.0%) нь Баянгол дүүрэгт байна. Дүүргүүдийг нийслэлийн дүнд эзлэх байр сууриар авч үзэхэд Баянзүрх дүүрэгт хамгийн их буюу 37.8 хувь нь, Багануур, Баганхангай, Налайх дүүрэгт хамгийн бага 4.7 хувь нь байна.

Нийт боломжит ажиллах хүч өмнөх оноос 985 (63.5%) хүнээр буурч, хүйсээр нь харвал 1660 (65.4%) нь эрэгтэй, 877 (34.6%) нь эмэгтэй байна.

Түүнчлэн насны бүлгээр авч үзэхэд 28.8 хувийг 25-34 насны бүлэгт хамаарагдаж байгаа иргэд хамгийн өндөр хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 10.**БОЛОМЖИТ АЖИЛЛАХ ХҮЧ, хүйсээр, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст**

Насны бүлэг	2023				2024				2025			
	Бүгд		Эмэгтэй		Бүгд		Эмэгтэй		Бүгд		Эмэгтэй	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	1 770	100.0	1 327	100.0	1 552	100.0	1 016	100.0	2 537	100.0	877	100.0
15-24	-	-	-	-	-	-	-	-	137	5.3	137	15.6
25-34	222	12.6	222	16.8	394	25.4	167	16.4	730	28.8	-	-
35-44	442	25.0	440	33.2	152	9.8	152	15.0	551	21.7	121	13.8
45-54	552	31.2	332	24.8	521	33.6	521	51.3	473	18.7	241	27.5
55+	554	31.2	333	25.2	485	31.2	176	17.3	646	25.5	378	43.1

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч:

Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг насны бүлгээр нь задалбал 26.1 хувь нь 15-19, 11.3 хувь нь 20-24, 8.1 хувь нь 25-29, 6.3 хувь нь 30-34, 6.9 хувь нь 35-39, 2.4 хувь нь 40-44, 2.7 хувь нь 45-49, 4.2 хувь нь 50-54, 32.0 хувь нь 55-аас дээш насныхан тус тус эзэлж байна.

2025 онд ажиллах хүчний судалгааны үр дүнгээр бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам нь 67641 болж өмнөх оноос 1154 (1.7%) хүнээр буурсан бол, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч 137 байна. Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн амын 61.2 хувь нь эмэгтэй, 38.8 хувь нь эрэгтэй байгаа бол цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид бүгд эрэгтэй байна.

ХҮСНЭГТ 11.**АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ, хүйсээр, насны бүлгээр, 2025 оны жилийн эцэст**

Насны бүлэг	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам			Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	тоо					
Бүгд	67 641	26 263	41 378	137	137	-
15-19	17 623	8764	8859	-	-	-
20-24	7 620	3304	4316	-	-	-
25-29	5 463	619	4844	-	-	-
30-34	4 260	1458	2802	-	-	-
35-39	4 696	427	4269	-	-	-
40-44	1 600	853	747	-	-	-
45-49	1 822	1400	422	-	-	-
50-54	2 815	846	1969	137	137	-
55+	21 742	8 592	13 150	-	-	-

АРГА, АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Үндэсний Статистикийн хороо нь олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу 2006 оноос эхлэн "Ажиллах хүчний түүвэр судалгаа" (АХС)-г улирлаар явуулж байна.

Энэхүү **судалгааны зорилго** нь хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тухайн хугацаа буюу сүүлийн 7 хоногоор тодорхойлж, дүн шинжилгээ хийх тоон мэдээллийн багцыг бий болгоход оршино.

Судалгааг 2006-2018 онуудад Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 1982 оны 13-р бага хурлын тогтоолын дагуу боловсруулагдсан Монгол Улсын хөдөлмөрийн статистикийн аргачлал, арга зүйн дагуу явуулж байсан.

Харин **2019 оноос эхлэн шинэ аргачлал, ойлголт тодорхойлолтын дагуу явуулж байна.** Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 2013 онд болсон 19 дүгээр бага хурлаар 1982 оны 13 дугаар бага хурлаас баталсан аргачлал нь хөдөлмөрийн зах зээлийн бодит дүр зургийг төдийлөн илэрхийлж чадахгүй, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлоход дутагдалтай байгааг онцолж, аргачлалыг шинэчлэх шийдвэр гаргасан юм. Тухайлбал, ажилгүйдлийн түвшин дангаараа ажиллах хүчний дутуу ашиглалтыг бүрэн харуулж чадахгүй байгаа тул ихэнх орнуудын ажиллах хүч, ажилгүйдлийн түвшнийг тооцоход ашиглаж байгаа эдийн засгийн идэвхтэй хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг шинэчлэхийг чухалчилсан.

Хөдөлмөрийн зах зээл маш хурдацтай өөрчлөгдөж буй өнөөгийн цаг үетэй хөл нийлүүлэн, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг бодитоор харуулахын тулд бид олон улсын шинэ аргачлалыг өөрийн орны онцлогт тусган нэвтрүүлж, Үндэсний Статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А- 09/08 тоот хамтарсан тушаалаар "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг батлан 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

Хөдөлмөрийн статистикийн аргачлалыг шинэчилснээр хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх илүү нарийвчилсан мэдээлэл, түүнчлэн хөдөлмөрийн дутуу

ашиглалтыг бүрэн харуулах статистикийн үзүүлэлтийг шинээр бий болгож, бодлого боловсруулагчдыг зохих мэдээллээр хангах юм.

Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 19-р бага хурлын "Ажил, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний дутуу ашиглалт"-ын талаарх тогтоолын дагуу хөдөлмөрийн статистикийн ойлголт, аргачлалд гарсан томоохон өөрчлөлтийг тусган харуулж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөрийн статистикийг НҮБ-ын үндэсний тооцооны системтэй зарчмын хувьд уялдуулах боломжтой болсон

- Цалин авч байгаа эсэхээс үл хамааран шинээр **ажил, түүний хэлбэрүүдийг** тооцох үзүүлэлтийг тодорхойлж, ялангуяа, өөрийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэл явуулж буй хүмүүс, цалингүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан зэргийг агуулга талаас нь тайлбарлаж, тодорхойлолтыг бий болгон хэмжих үзүүлэлтийг тогтоосон

Цалин, ашгийн төлөө ажиллаж байгаа хөдөлмөр эрхлэлтийн тодорхойлолт, үзүүлэлтийг сайжруулсан (Ингэснээр бусад төрлийн ажил, тухайлбал, өөрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл явуулж буй хүмүүс, цалингүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан зэргийг хөдөлмөр эрхлэлтээс ялгах боломжтой болж байгаа юм).

Ажиллагчдын **үндсэн ажлын** шалгуур нь хуучнаар хамгийн их цалин хөлс, орлого олдог ажил нь байсан бол шинэ аргачлалын дагуу цалин, орлогоос үл хамааран хамгийн их цаг зарцуулдаг ажлыг үндсэн ажил гэж тодорхойлсон.

Ажил: Аль ч нас, хүйсийн хүн амын бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх албан ёсны болон албан бус бүхий л үйл ажиллагааг ойлгоно. Ажил гэсэн ойлголтод бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхээс өөр үйлдэл (гуйлга гуйх, хулгай хийх), өөрийн биеийг арчлах (хувийн ариун цэвэр сахиx, арьс арчилгаа хийх, өөрийгөө сувилах) болон тухайн хүний өмнөөс

өөр хүн гүйцэтгэж үл чадах үйл ажиллагаа (унтах, суралцах, өөрийгөө хөгжүүлэх, амрах) хамаарахгүй (заалт 6, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажлын хэлбэр: Харилцан ялгаатай зорилгоор хийж гүйцэтгэдэг, өөр хоорондоо адилгүй олон төрлийн ажлыг үйлдвэрлэлийнх нь зориулалтаар (өөрийн эцсийн хэрэглээ болон бусдын хэрэглээнд), үйл ажиллагааных нь зорилгоос нь (цалин хөлстэй, орлого олох эсэх) хамаарч тус тусад нь хэмжихийг ойлгоно (заалт 7, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллах хүчний дутуу ашиглалтыг хэмжихдээ уламжлалт ажилгүйдлийн түвшин гэдэг үзүүлэлтээс илүү өргөн хүрээнд авч үзсэн байна. Үүнтэй уялдуулан хөдөлмөрийн статистикийн үндсэн үзүүлэлтийн мэдээллийн гол эх үүсвэр болох Ажиллах хүчний судалгааг шинэ ойлголт тодорхойлолт, аргачлалын дагуу явуулж байна.

Хөдөлмөрийн насны хүн ам: 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна (заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1). **Хөдөлмөрийн насны дээд хязгаарыг** тогтоож өгөхгүй байхыг анхааруулсан.

Ажиллах хүч: Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм (заалт 11, 16, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

$$\text{Ажиллах хүч} = \text{Ажиллагчид} + \text{Ажилгүй хүн}$$

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам: Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас энэ боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр

өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ (заалт 16,55, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллагч: Хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ (заалт 27, ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Өргөтгөсөн ажиллах хүч: Ажиллах хүч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Өргөтгөсөн ажиллах хүч} = \text{Ажиллах хүч} + \text{Боломжит ажиллах хүч}$$

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажиллах хүчний оролцооны түвшин} = \text{Ажиллах хүч} / \text{Хөдөлмөрийн насны хүн ам} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \text{Ажиллагчдын тоо} / \text{Хөдөлмөрийн насны хүн ам} * 100\%$$

Хөдөлмөрийн дутуу ашиглалт: Хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно (заалт 40, 42 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

Ажилгүйдлийн түвшин: Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-1).

$$\text{ХДАТ}_1 = \text{Ажилгүй хүний тоо} / \text{Ажиллах хүч} * 100\%$$

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч: Тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй,

нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ (заалт 43 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин: Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй хүний тооны нийлбэрийг ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-2).

$ХДАТ2 = \text{Ажилгүй хүний тоо} + \frac{ЦХХББХЭ}{\text{Ажиллах хүч}} * 100\%$

Ажилгүй хүн: Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Үүнд:

- хөдөлмөр эрхлээгүй** гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг
- ажил хийхэд бэлэн** гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг
- ажил хайж байгаа** гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

Боломжит ажиллах хүч: Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт

40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

- Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч** буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн
- Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн** буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.

Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин: Боломжит ажиллах хүч болон ажилгүй хүний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-3).

$ХДАТ3 = \text{Ажилгүй хүний тоо} + \text{боломжит ажиллах хүч} / \text{Ажиллах хүч} * 100\%$

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин: Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу ажилгүй хүн, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-4).

$ХДАТ4 = \text{Ажилгүй хүний тоо} + \frac{ЦХХББХЭ + БХАХ \text{ хүч}}{\text{өргөтгөсөн ажиллах хүч}} * 100\%$

Хөдөлмөр эрхлэлтийн статус гэж эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн ажиллагчийг ажиллаж байгаа эдийн засгийн нэгж (хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага эсэх) болон эрх мэдэл, ажил үүргээр нь ангилахыг ойлгоно.

Ажил олгогч гэж ашиг олох зорилгоор тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагч гэдэгт ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй. Ажил олгогчдыг дотор нь аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч (захирал, менежер) болон өрхийн зах зээлийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж хоёр ангилна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулж байгаа ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

Цалин хөлстэй ажилтангүй бие даасан ажиллагч гэж өөрийн хөрөнгөөрөө бие даан, эсвэл бусадтай хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, тухайн хугацаанд ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй гэдэг нь өөрөөсөө, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүнээсээ өөр нэг ч хүн ажилчнаар авч ажиллуулаагүй байхыг ойлгоно. Эдгээр хөдөлмөр 13 эрхлэгчдийг дотор нь цалин хөлстэй ажилтангүй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч болон цалин хөлстэй ажиллагчгүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж хоёр ангилна.

Цалин хөлстэй ажилтангүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч

ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажилч юм.

Цалин хөлстэй ажилтангүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажилч юм.

Гүйцэтгэх гэрээлэгч гэж эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагч нь тухайн эдийн засгийн нэгжийн цалин хөлстэй ажиллагч биш боловч ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, орлого болон зах зээлд гарах боломж зэрэг нь уг эдийн засгийн нэгжээс хамаардаг. Мөн эдгээр ажиллагч нь тэдний үйлдвэрлэлийн (бүтээмжтэй) үйл ажиллагаанд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлынх нь үр шимийг шууд хүртдэг эдийн засгийн өөр нэгжээс хараат, ашгийн төлөө ажиллагч юм.

Цалин хөлстэй ажиллагч гэж ажиллаж буй эдийн засгийн нэгжээ эзэмшдэггүй, үйл ажиллагааны шийдвэрт оролцохгүйгээр тухайн нэгжид албан болон албан бусаар хөдөлмөр эрхлэн, ажилласан цаг, хийж гүйцэтгэсэн ажлынхаа (зарим тохиолдолд хийж гүйцэтгэсэн ажлынхаа үйл ажиллагаа тус бүрт) эсвэл худалдаа, үйлчилгээ (тоо хэмээ, захиалгын тоогоор) үзүүлснийхээ төлбөр болгон мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг ажиллагч юм. Цалинтай ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн гэрээний нөхцөл, хөдөлмөрийн харилцааны зохицуулалтаас нь хамаарч 4 ангилна.

Цалин хөлстэй байнгын ажиллагч гэж ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч

юм. Эдгээр ажиллагчид нь албан болон 14 албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч орно.

Цалин хөлстэй түр ажиллагч гэж хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3 ба түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.

Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч гэж ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.

Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид гэж цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй ажиллагч юм.

Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн гэж өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг.

